



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/176/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdene.g@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг 14.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг алдаа илэрсэнд аудитын явцад залруулга аудитын явцад залрууллаа.	17
4.2 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
4.3 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,411,561.79	131,898,737.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	5,248,062.21
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	5,248,062.21
3121	Төгрөг	00.00	5,248,062.21
31211	Төрийн сангийн харилцах	00.00	5,248,062.21
33	АВЛАГА	00.00	105,162,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	105,162,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	33,411,561.79	21,488,674.79
351	Түүхий эд материал	23,882,323.79	18,777,274.79
35130	Эм боох материал	23,882,323.79	18,777,274.79
354	Хангамжийн материал	9,529,238.00	2,711,400.00
35440	Түлш, шатах тослох материал	1,657,750.00	1,002,150.00
35460	Хүнсний материал	7,871,488.00	1,709,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	971,529,621.92	1,008,027,345.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	971,529,621.92	1,008,027,345.97
392	Биет хөрөнгө	939,011,621.92	975,509,345.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	973,771,169.30	973,771,169.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-127,227,838.96	-138,594,901.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,799,260.00	76,799,260.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-41,524,987.84	-51,184,876.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	251,604,277.31	313,573,858.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-199,273,415.51	-206,062,951.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,937,751.00	29,887,751.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,074,593.38	-22,679,962.72
393	Биет бус хөрөнгө	32,518,000.00	32,518,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	32,518,000.00	32,518,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,004,941,183.71	1,139,926,082.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	100,546,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	100,546,000.00
413	Өглөг	00.00	100,546,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	81,707,400.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	18,838,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,004,941,183.71	1,039,380,082.97
51	Засгийн газрын хувь оролцоо	1,004,941,183.71	1,039,380,082.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	727,738,725.60	727,738,725.60
51101	Өмч: - төрийн	727,738,725.60	727,738,725.60
512	Хуримтлагдсан үр дүн	-238,202,457.38	-203,763,558.12
51210	Өмнөх үеийн үр дүн	-238,202,457.38	-238,202,457.38
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	34,438,899.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	515,404,915.49	515,404,915.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,004,941,183.71	1,139,926,082.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	774,364,749.92	1,569,298,453.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,177,025.92	397,049,801.01
120	Нийтлэг татварын бус орлого	68,177,025.92	397,049,801.01
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	706,187,724.00	510,179,252.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	652,463,800.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	652,463,800.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	662,069,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,062,100.00	359,195,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	117,100.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,860,000.00	359,195,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	21,061,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	21,061,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	49,661,824.00	129,922,652.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	49,661,824.00	129,922,652.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	742,234,260.31	1,333,767,553.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	742,234,260.31	1,333,767,553.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	741,494,260.31	1,281,967,553.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	525,134,200.00	573,417,077.03
210101	Үндсэн цалин	295,210,800.00	317,994,782.00
210102	Нэмэгдэл	177,094,800.00	202,377,005.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,547,000.00	00.00
210104	Урамшуулал	44,281,600.00	53,045,290.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,893,100.00	80,396,078.76
210201	Тэтгэврийн даатгал	49,887,700.00	55,124,150.99
210202	Тэтгэмжийн даатгал	5,251,300.00	9,345,636.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,201,100.00	4,351,321.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,050,300.00	1,052,269.93
210205	Эрүүл мэндийн даатгал	10,502,700.00	10,522,699.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,478,047.00	17,204,712.00
210301	Гэрэл, цахилгаан	6,410,032.00	2,820,112.00
210302	Түлш, халаалт	10,947,315.00	14,160,000.00
210303	Цэвэр, бохир ус	120,700.00	224,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,165,335.00	52,310,472.00
210401	Бичиг хэрэг	1,575,100.00	3,672,100.00
210402	Тээвэр, шатахуун	12,127,585.00	28,187,022.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	889,500.00	2,325,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	403,300.00	964,329.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,169,850.00	17,161,221.00
2105	Нормативт зардал	57,267,697.13	511,935,765.01
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,242,020.13	439,312,827.01
210502	Хоол, хүнс	5,905,677.00	72,457,938.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,120,000.00	165,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,928,830.00	3,316,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,967,586.00	1,681,600.00
210604	Урсгал засвар	3,588,244.00	1,635,000.00
2107	Томиллот, зочны зардал	1,010,841.00	3,339,700.00

Эрдэнэмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	1,010,841.00	3,339,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,447,404.00	1,120,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,466,004.00	00.00
210807	Газрын төлбөр	15,400.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	750,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,156,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,168,806.18	38,927,148.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,043,200.00	10,505,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,125,606.18	28,421,848.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	740,000.00	51,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	740,000.00	51,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	51,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	740,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	32,130,489.61	235,530,899.26
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	29,700,000.00	00.00
225003	Хөрөнгө оруулалтын гарз	29,700,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-29,700,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,430,489.61</u>	<u>235,530,899.26</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	695,220,725.60	229,343,939.25	-193,691,640.30	730,873,024.55
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	695,220,725.60	229,343,939.25	-193,691,640.30	730,873,024.55
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,239,443.78	-2,239,443.78
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	727,738,725.60	515,404,915.49	-238,202,457.38	1,004,941,183.71
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	727,738,725.60	515,404,915.49	-238,202,457.38	1,004,941,183.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	727,738,725.60	515,404,915.49	-238,202,457.38	1,004,941,183.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	235,530,899.26	235,530,899.26
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	727,738,725.60	515,404,915.49	-2,671,558.12	1,240,472,082.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	706,187,724.00	1,067,086,652.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	706,187,724.00	1,067,086,652.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	652,463,800.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	652,463,800.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	662,069,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,062,100.00	359,195,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	117,100.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,860,000.00	359,195,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	21,061,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	21,061,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	49,661,824.00	24,760,652.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	49,661,824.00	24,760,652.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	706,187,724.00	1,061,838,589.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	706,187,724.00	1,061,838,589.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	705,447,724.00	1,010,038,589.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	525,134,200.00	655,124,477.03
210101	Үндсэн цалин	295,210,800.00	317,994,782.00
210102	Нэмэгдэл	177,094,800.00	284,084,405.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,547,000.00	00.00
210104	Урамшуулал	44,281,600.00	53,045,290.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,893,100.00	80,396,078.76
210201	Тэтгэврийн даатгал	49,887,700.00	55,124,150.99
210202	Тэтгэмжийн даатгал	5,251,300.00	9,345,636.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,201,100.00	4,351,321.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,050,300.00	1,052,269.93
210205	Эрүүл мэндийн даатгал	10,502,700.00	10,522,699.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,410,847.00	19,304,712.00
210301	Гэрэл, цахилгаан	6,410,032.00	4,520,112.00
210302	Түлш, халаалт	10,880,115.00	14,560,000.00
210303	Цэвэр, бохир ус	120,700.00	224,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,357,554.00	47,760,100.00
210401	Бичиг хэрэг	1,080,700.00	2,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,875,000.00	26,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,517,400.00	3,132,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	638,254.00	1,477,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,246,200.00	14,550,000.00
2105	Нормативт зардал	58,364,302.00	183,677,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,357,700.00	99,600,050.00
210502	Хоол, хүнс	12,824,102.00	83,912,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,182,500.00	165,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,602,180.00	6,235,972.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	4,600,972.00
210604	Урсгал засвар	3,035,000.00	1,635,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,010,841.00	3,339,700.00
210702	Дотоод албан томилолт	1,010,841.00	3,339,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,589,700.00	1,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00

Эрдэнэмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,564,300.00	00.00
210807	Газрын төлбөр	15,400.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	750,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,200,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,085,000.00	13,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,085,000.00	13,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	740,000.00	51,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	740,000.00	51,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	51,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	740,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>00.00</u>	<u>5,248,062.21</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	5,248,062.21
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	5,248,062.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	735,879,800.00	702,643,389.79	33,236,410.21	95.5
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	735,879,800.00	702,643,389.79	33,236,410.21	95.5
4	Бараа, үйлчилгээний зардал	735,879,800.00	702,643,389.79	33,236,410.21	95.5
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	536,358,000.00	536,353,942.03	4,057.97	100.0
6	Үндсэн цалин	295,210,000.00	316,613,342.00	(21,403,342.00)	107.3
7	Нэмэгдэл	185,641,000.00	166,695,310.03	18,945,689.97	89.8
8	Урамшуулал	55,507,000.00	53,045,290.00	2,461,710.00	95.6
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,408,200.00	70,232,983.76	2,175,216.24	97.0
10	Тэтгэврийн даатгал	50,954,000.00	44,961,055.99	5,992,944.01	88.2
11	Тэтгэмжийн даатгал	5,363,500.00	9,345,636.10	(3,982,136.10)	174.2
12	ҮОМШӨ ний даатгал	4,290,900.00	4,351,321.86	(60,421.86)	101.4
13	Ажилгүйдлийн даатгал	1,072,700.00	1,052,269.93	20,430.07	98.1
14	Эрүүл мэндийн даатгал	10,727,100.00	10,522,699.88	204,400.12	98.1
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,426,400.00	19,304,712.00	121,688.00	99.4
16	Гэрэл цахилгаан	4,641,800.00	4,520,112.00	121,688.00	97.4
17	Түлш, халаалт	14,560,000.00	14,560,000.00	-	100.0
18	Цэвэр, бохир ус	224,600.00	224,600.00	-	100.0
19	Хангамж, бараа материалын зардал	27,382,200.00	27,360,100.00	22,100.00	99.9
20	Бичиг хэрэг	2,300,000.00	2,300,000.00	-	100.0
21	Тээвэр (шатахуун)	16,000,000.00	16,000,000.00	-	100.0
22	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,132,200.00	3,132,200.00	-	100.0
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,477,900.00	22,100.00	98.5
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	4,450,000.00	4,450,000.00	-	100.0
25	Нормативт зардал	57,670,000.00	28,133,180.00	29,536,820.00	48.8
26	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	40,000,000.00	12,278,180.00	27,721,820.00	30.7
27	Хоол, хүнс	15,690,000.00	15,690,000.00	-	100.0
28	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,980,000.00	165,000.00	1,815,000.00	8.3
29	Эд хогшил худалдан авах	5,135,000.00	3,758,472.00	1,376,528.00	73.2
30	Багаж, техник, хэрэгсэл	3,500,000.00	2,123,472.00	1,376,528.00	60.7
31	Урсгал засвар	1,635,000.00	1,635,000.00	-	100.0

Эрдэнэмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

32	Томилолт, зочны зардал	3,300,000.00	3,300,000.00	-	100.0
33	Дотоод албан томилолт	3,300,000.00	3,300,000.00	-	100.0
34	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,200,000.00	1,200,000.00	-	100.0
35	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	250,000.00	250,000.00	-	100.0
36	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00	-	100.0
37	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00	-	100.0
38	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	750,000.00	-	100.0
39	Бараа үйлчилгээний бусад зардал	13,000,000.00	13,000,000.00	-	100.0
40	Бараа үйлчилгээний бусад зардал	13,000,000.00	13,000,000.00	-	100.0
41	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	735,879,800.00	707,891,452.00	27,988,348.00	96.2
42	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	662,069,400.00	662,069,400.00	-	100.0
43	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	662,069,400.00	662,069,400.00	-	100.0
44	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,061,400.00	21,061,400.00	-	100.0
45	Орон нутгийн төсвөөс	21,061,400.00	21,061,400.00	-	100.0
46	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,749,000.00	24,760,652.00	27,988,348.00	46.9
47	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	52,749,000.00	24,760,652.00	27,988,348.00	46.9
48	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
49	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,248,062.21	(5,248,062.21)	
50	АЖИЛЛАГСДЫН ТОО	37.00	37.00	-	100.0
51	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
52	Гүйцэтгэх ажилтан	25.00	24.00	1.00	96.0
53	Үйлчлэх ажилтан	11.00	12.00	(1.00)	109.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг /

№	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	359,195,200.00
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	359,195,200.00
4	Бараа, үйлчилгээний зардал	307,395,200.00
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,770,535.00
6	Үндсэн цалин	1,381,440.00
7	Нэмэгдэл	117,389,095.00
8	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,163,095.00
9	Тэтгэврийн даатгал	10,163,095.00
10	Хангамж, бараа материалын зардал	20,400,000.00
11	Тээвэр (шатахуун)	10,300,000.00
12	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	10,100,000.00
13	Нормативт зардал	155,544,370.00
14	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	87,321,870.00
15	Хоол, хүнс	68,222,500.00
16	Эд хогшил худалдан авах	2,477,500.00
17	Багаж, техник, хэрэгсэл	2,477,500.00
18	Томиллолт, зочны зардал	39,700.00
19	Дотоод албан томиллолт	39,700.00
20	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,800,000.00
21	Бусад урсгал шилжүүлэг	51,800,000.00
22	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	51,800,000.00
23	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	359,195,200.00
24	Нэмэлт санхүүжилтийн орлого	359,195,200.00
25	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	359,195,200.00
26	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
27	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-
30	АЖИЛЛАГСДЫН ТОО	37.00
31	Удирдах ажилтан	1.00
32	Гүйцэтгэх ажилтан	24.00
33	Үйлчлэх ажилтан	12.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэмандал сумын ЭМТ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэмандал сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэмандал сумын ЭМТ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “хүн амын эрүүл мэндийг төрийн онцгой анхаарал, ивээлд авах”, 4.1.2-д “хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх”, 4.2.1-д “хүмүүнлэг, энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэг, ололт, нотолгоо, орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэт аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх”, 4.2.2-д “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож, улмаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан, нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг хангах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Байгууллагын бүх түвшинд ёс зүйтэй чадварлаг хамт олныг бүрдүүлж иргэдэд эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай тэгш хүртээмжтэй хүргэх”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/585 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/605 дугаар тушаал “Журам, аргачлал батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжтэй тул үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэмандал сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 735.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 73.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 51.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 134.9 сая төгрөгөөр буюу 13.4 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Төрийн сангийн харилцах	-	5.25	5.25	-
Авлага	-	105.16	105.16	-
Бараа материал	33.41	21.49	(11.92)	(35.69)
Үндсэн хөрөнгө	971.53	1,008.00	36.47	3.75
Нийт хөрөнгө	1,004.94	1,139.90	134.96	13.43
Өр төлбөр	-	100.50	100.50	-

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,004.94	1,039.38	34.44	3.43
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,004.9	1,139.9	134.9	13.4

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Харилцахын үлдэгдэл 5.2 сая төгрөг байна.

Харилцахын данс нь тайлант жилд үндсэн үйл ажиллагааны батлагдсан төсвийн гүйцэтгэл 5.2 сая төгрөгөөр хэмнэгдэж, харилцах дансанд төвлөрүүлсэн байна.

- Авлагын үлдэгдэл 105.1 сая төгрөг байна.

Авлагын данс нь тайлант жилд эрүүл мэндийн даатгалын санд 423.5 сая төгрөгийн даатгуулагчийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэхийг хүргүүлснээс 318.4 сая төгрөгийн санхүүжилт олгогдож 105.1 сая төгрөгийн дутуу санхүүжилтээр авлага үүссэн байна.

- Бараа материалын үлдэгдэл 35.7 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 33.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 236.5 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 332.1 сая төгрөг нийт 568.6 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 580.5 сая төгрөгийн зарцуулалт гарч, 21.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 3.7 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 971.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 64.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 28.4 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 1,008.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөрийн үлдэгдэл 100.5 сая төгрөг байна.

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу санхүүжилт олгосонтой холбоотойгоор цалин, шимтгэлийн 100.5 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 34.4 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/ төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/эрүүл мэндийн даатгалын сангаас/	49.66	129.92	80.26
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/улсын төсөв/	652.46	662.07	9.61
Нэмэлт санхүүжилтийн орлого	4.06	359.20	355.13
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	42.25	64.92	22.67
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	25.92	332.13	306.21
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/эрүүл мэндийн даатгалын сангаас/	-	21.06	21.06
Дээд шатны төсөв захирагчаас	-	-	-
Үйл ажиллагааны орлого	774.36	1,569.30	794.93
Цалин, шимтгэлийн зардал	596.03	817.23	221.20
Бусад бараа үйлчилгээний зардал	145.47	665.83	520.36
Урсгал шилжүүлэг	0.74	51.80	51.06

Үйл ажиллагааны зардал	742.24	1,534.86	792.62
Үйл ажиллагааны бус зардал /ҮХХ-ны гарз/	29.70		(29.70)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2.42	34.44	32.01

Эрдэнэмандал сумын ЭМТ-ийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 110.9 сая төгрөгөөр буюу 15.7 хувиар өссөн нь ковид 19 холбоотойгоор хэвтэн эмчлүүлэгч, дархлаажуулалт, пср, пср-ийн зөөвөр, урьдчилан сэргийлэх зэрэг эрүүл мэндийн цогц үйлчилгээ авагч даатгуулагчийн тусламж үйлчилгээ нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 910.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 174.6 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 735.8 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр 96.2 хувь буюу 707.9 сая төгрөгийн санхүүжилт авч эрүүл мэндийн даатгалын сангаас 27.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна. Мөн тус байгууллага нь гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор 105.1 сая төгрөгийн авлага үүссэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМГ-аас 51.8 сая төгрөг, аймгийн ИТХ-аас 2.5 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас ковид 19 цар тахалтай холбоотойгоор хэвтэн эмчлүүлэгч болон дархлаажуулалтаар 304.8 сая төгрөг нийт 359.1 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд ковид 19 цар тахалтай холбоотой 441 даатгуулагчийг хэвтэн эмчлүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг, 7783 даатгуулагчид дархлаажуулах вакцины үйлчилгээг тус тус үзүүлсний зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас 304.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээ үзүүлэх журмын дагуу зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-аас хүчилтөрөгчийн аппарат худалдан авахад 2.5 сая санхүүжилт олгосонг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймгийн ЭМГ-аас Эрүүл Мэндийн Сайдын 2021 оны А/496, А/585 тушаалын дагуу нэгдсэн эмнэлгийн 37 албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж урамшуулалд зориулж 51.8 сая төгрөгийг мөн сүрьеэгийн сорьц хүргэх шатахууны зардалд 0.039 сая төгрөгийг тус тус зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрдэнэмандал сумын ЭМТ нь 2021 онд ковид 19 цар тахалтай холбоотойгоор 7321 иргэнд ПСР-ийн шинжилгээг, 3080 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэгийг, 8491 иргэнд дархлаажуулалтын вакцинийг, 441 иргэнд хэвтэн эмчлүүлэх үйлчилгээг нийт 19333 иргэнд эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 117 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 85 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 735.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 95.5 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Ковид 19 цар тахалтай холбоотойгоор иргэн, ААН-ээс 64.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг хандиваар орж ирсэнг бүртгэл тайланд тусгасан байна.
2. Тайлант жилд коронавируст халдвараар өвчилсөн иргэдэд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлээгүй байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгсэлд 23.3 сая төгрөгийн шатахуун, 1.6 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан, орон тооны 2 жолоочтой, жолоочийн цалинд 30.5 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэмандал сумын ЭМТ нь 2021 онд нийт 1,206.5 сая төгрөгийн 168 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 954.5 сая төгрөгийн 119 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулсан байна. 251.9 сая төгрөгийн 49 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, 2022 оны шилэн дансны мэдээллийг хуулинд заасан хугацаанд тогтмол, бүрэн мэдээлэх албан шаардлага хүргүүлэх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгээгүй, зарим албан хаагчдын НДШ-ийг зөрүүтэй тооцсон зөрчил илэрсэнд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах, шимтгэлийг үнэн зөв тооцож ажиллах 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,704.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 944.6 сая төгрөгийн алдааг залруулж, 3,759.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүнг тулган шалгахад үндсэн хөрөнгийн нэмэгдлийг 22.2 сая төгрөгөөр, авлагыг үлдэгдлийг 922.4 сая төгрөгөөр нийт 944.6 сая төгрөгийг дутуу тусгаж тайлагнасанг аудитын явцад залруулга хийлээ.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Тус байгууллага нь эрүүл мэндийн даатгалын сангийн дутуу санхүүжилттэй холбоотой 105.1 сая төгрөгийн авлага, ажиллагчид болон бараа үйлчилгээтэй холбогдсон 100.5 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтын дагуу Өр, авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 237 нэр төрлийн 189.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр заалтын дагуу ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны зааврын 4.39-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
1	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	Тус байгууллага нь эрүүл мэндийн даатгалын сангийн дутуу санхүүжилттэй холбоотой 105.1 сая төгрөгийн авлага, ажиллагчид болон бараа үйлчилгээтэй холбогдсон 100.5 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.	1	205.7							1	205.7
2		Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 237 нэр төрлийн 189.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй	1	189.3							1	189.3
Дүн			2	394.9							2	394.9
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	49 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1							1		
Дүн			1							1		
Нийт дүн			3	394.9						1	3	394.9